



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 12 сарын 11 өдөр

Дугаар А/548

Улаанбаатар хот

Баянгол дүүргийн 164 дүгээр
цэцэрлэгийн хөрөнгийг данснаас
дансанд шилжүүлэн бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу хавсралтад заасан нийт 143,899.0 /нэг зуун дөчин гурван мянга найман зуун ерэн есөн/ төгрөгийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг холбогдох дансанд шилжүүлэн бүртгэхийг Баянгол дүүргийн 164 дүгээр цэцэрлэг /Б.Нэргүй/-т зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, зарчмыг баримтлан бүртгэж, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Баянгол дүүргийн 164 дүгээр цэцэрлэг /Б.Нэргүй/-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

115050001469

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын
газрын даргын 2019 оны 12 дугаар
сарын 11 өдрийн 41 тоот тушаалын хавсралт

1549

Данснаас дансанд шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Баянгол дүүргийн 164 дүгээр цэцэрлэг

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Үзүүлэлт	Үйлдвэрлэсэн он	Ашиглалтад авсан он	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэлийн анхны үнэ /төгрөгөөр/		Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Дансны нэр	
									Нэгж үнэ	Нийт үнэ			Шилжүүлэх данс	Бүртгэх данс
1	Утасны аппарат	Panasonic	саарал	1999	1999	дунд	ш	1	38,999.0	38,999.0	38,999.0	-	Тавилга, эд хогшил	Тоног төхөөрөмж
Тоног төхөөрөмжийн дүн								1		38,999.0	38,999.0	-		
2	Бикс /эрүүл мэндийн хайрцаг/		төмөр	2009	2009	дунд	ш	1	75,000.0	75,000.0	66,875.0	8,125.0	Тавилга, эд хогшил	Хангамжийн материал
3	Чагнуур			2009	2009	дунд	ш	1	29,900.0	29,900.0	26,661.2	3,238.8		
Тавилга, эд хогшлын дүн								2		104,900.0	93,536.2	11,363.8		
НИЙТ ДҮН								3		143,899.0	132,535.2	11,363.8		